



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 4/418

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл Эх ХХК-ийн өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

3.Нямбаяр - (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга),

Гишүүдэд: Д.Сандагдорж - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Дэд бүтцийн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн),

Л.Энхцэцэг - (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Геодез, зураг зүйн хяналтын улсын байцаагч),

П.Ханбүргэд- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт сурталчилгаа, хууль тогтоомжийн сан, хүний эрхийн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн),


Нарийн бичгийн дарга: Б.Бат-Оргил - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн хэлтсийн Эрх зүйн хяналт, шинжилгээ-үнэлгээ, хууль сахиулах бодлого, үйл ажиллагаа зохион байгуулах Ахлах мэргэжилтэн),

2.Хөвсгөл Эх ХХК-ийн өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, санал боловсруулах ажлыг зохион байгуулж аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (3.Нямбаяр)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712011261